



**ӨМНӨ ГОВЬ АЙМГИЙН ИТХ-ЫН ШИЙДВЭР  
ҮНДЭСНИЙ СПОРТЫГ ХӨГЖҮҮЛЭХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ**

2008 оны 9 дүгээр сарын 16-ны өдөр Даланзадгад

Дугаар 85

Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.2 “ж”, Засгийн газрын 2007 оны 150-р тогтоолыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс **ТОГТООХ** нь:

Нэг. Үндэсний спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөрийг нэгдүгээр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулж, явц, үр дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд, жил бүр тайлагнаж ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Эрдэнэбат/-д даалгасугай.

**ХУРЛЫН ДАРГА**

**С.ЦЭРЭНБАЯР**